

ОЙРАДЫН СЭНГЭ ХУНТАЙЖ БА ОРОСЫН ХАРИЛЦААНЫ
ЗАРИМ АСУУДАЛД

Н.Баяргэгцэг¹

Товч агуулга

Дөрвөн Ойрадын тэргүүн Баатар хунтайж нас барсаны дараа түүний орыг хүү Сэнгэ нь залгамжилсан юм. Сибирийн ард түмнээс, тэр дундаа тэлэнгид, кыргыз нараас алба авах нь Сэнгэ-Оросын харилцааны гол асуудал байв. Тиймээс Сэнгийн үед Ойрад-Оросын харилцаа ихээхэн төвөгтэй, зөрчил тэмцэл ихтэй байсан юм.

Түлхүүр үгс

Дөрвөн ойрад, Орос-Ойрадын харилцаа, Сибирийн уугуул ард түмэн, кыштым, Сэнгэ хунтайж

Ойрадын түүхийн судалгаанд Сэнгийн богинохон хаанчлалын үед Ойрадын гадаад дотоод бодлогийн хувьд нэлээд зөрчил тэмцэл ихтэй байсан гэж үздэг билээ. Шинжаанд хэвлэгдсэн “Ойрад Монголын товч түүх” зохиолд “Сэнгийг засаг барьснаас хойш Орос лугаа болсон гадаад явдлын тэмцэл нэмэгдсэнээс биш хасагдсангүй” гээд “Ойрад-Оросын харилцааны зөрчил “ёслолын журам”-ын зөрчил, тэлэнгүүд нараас татвар авах гэсэн хоёр асуудал дээр төвлөрч байв”² гэж зөрчлийн шалтгааныг оновчтой тодорхойлжээ. Үнэхээр Сэнгэ хунтайжийн үед Сибирийн ард түмэн киргиз, тува, тэлэнгид нараас хэн алба авах вэ? гэдэг асуудал Ойрад-Оросын харилцааны зөрчлийг улам хурцатгах гол асуудал болж байсан юм. Түүний эцэг Баатар хунтайж кыргыз, тэлэнгид нараас алба авахын зэрэгцээ Оросын хааныг тэднээс алба авахыг зөвшөөрч, тэдгээр ард түмнийг хоёр улсад алба төлөгч, хоёр улсын харъяат болгож зөрчилтэй асуудлыг шийдэж, хоёр улсын харилцааг тогтворжуулж байсан юм. Харин Сэнгэ хунтайжийн хувьд тэдгээр ард түмэнд дангаар ноёрхож, алба авч, өөрийн харъяат болгохыг илүүд үзэж байв.

Сэнгэ тайшийн үед Ойрад-Оросын харилцааны онцлогийг авч үзвэл:

- 1663-1666 он: Энэ үед Ойрад-Оросын харилцаа найрсаг байсан боловч Ойрадын зүгээс тэлэнгид нарыг эргүүлэн өгөхийг Оросын хаанаас шаардаж байв.
- 1666-1670 он: Ойрад-Оросын харилцаа хурцадмал болж, Оросын элч нарыг үл хүндэтгэх, Сибирийн захирагч нарыг сүрдүүлэх, Хятад руу явсан элч худалдаачдыг дээрэмдэх зэргээр шахалт үзүүлж, тэлэнгид нарыг эргүүлэн авахыг оролдож байв.

1. Монгол Улсын Боловсролын Их Сургууль

2. Ойрад Монголын товч түүх. Дээд дэвтэр. Шинжаан.,2000. т.132

Баатар хунтайжийг нас барсаны дараа Сибирь дэх нөхцөлд өөрчлөлт гарч, Дээд Енисейн кыргызуудад Хотгойдын Алтан хан Лувсан тайж ноёрхлоо тогтоосоноор тэд Орос-Хотгойдын хоёрдмол албаг болжээ. Үүний зэрэгцээ Ойрадын ноёд Орос улстай улс төр, эдийн засгийн хувьд бие даан харилцахын зэрэгцээ тэлэнгид нарыг элдвээр дарамтлан довтлох явдал гарч байв. Үүний улмаас 1661 оны орчимд Томск болон Кузнецк хотуудад 100 гаруй өрх буюу 600 орчим тэлэнгид нар очиж суурьшжээ.³ Гэвч Сэнгэ хунтайж тэдгээр тэлэнгид нартай харилцаатай хэвээр байсан ба тэднийг захирч байсан Кокэ ба Мачик ноён нарт элч илгээж, “Томск, Кузнецкийн ойр хүмүүс илгээж хэрүүл маргаан үүсгэхгүй”⁴ байхыг сануулж байжээ.

Харин Ойрадын дотоод байдал тогтворгүй болсон 1654-1662 он хүртэл Хошуудын Аблай тайш, Очирт сэцэн болон Сэнгээс бусад Ойрадын нөлөө бүхий ноёд Тара, Тюмень, Тобольск хотуудын захирагч нарт бараг жил алгасахгүй элч илгээж⁵, Оросын хаанд морь болон бүс, дурдан, эмээл, хазаар зэргийг бэлэг болгон илгээж байв. Ойрадын ноёдоос илгээсэн элч болгон Москвад очиж хаанд бараалхахыг Сибирийн захирагч нараас хүсдэг байсан ч тэр бүр тэдний элчийг Москвагийн засгийн газар хүлээн авдаггүй байв. Гэсэн хэдий ч Ойрадын ноёд, тэр дотроо Хошуудын Аблай, Очирт сэцэн нар Сибирийн захирагч нартай харилцан элч илгээж, харилцан худалдаа хийж, урьдын адил харилцаагаа үргэлжлүүлсэн хэвээр байв. Гэхдээ Сибирийн захирагч нараас Ойрад руу илгээгдэж буй тэдгээр элч нар хязгаарлагдмал эрхтэй байсан тул Москваг бүрэн төлөөлж чадахгүй байв.⁶

Ийнхүү Тобольск хот руу удаа дараа элч илгээж байсны дүнд 1662 онд Хошуудын Аблай тайшийн элч Ирки-муллаг Москвад хүлээн авчээ. Ийнхүү хүлээн авах болсон нь Оросын төр засаг Ойрадын дотоод байдлыг ихэд сонирхож байсны зэрэгцээ Сибирийн захирагч нараас авсан мэдээллээ бататгах зорилготой байсныг илтгэж байна.

Сэнгэ хунтайж дотоод дахь өөрийн байр сууриа бэхжүүлж авсаны дараа Орос улсад элч илгээснээр Ойрад-Оросын тэргүүн нарын хооронд тасраад байсан харилцаа дахин сэргэсэн байна. Судлаачид Сэнгэ хунтайжийн Орос руу элч илгээсэн он цагийг 1663⁷, 1664⁸, 1665⁹ гэж харилцан адилгүй үзсэн байдаг. Тэрээр 1663 онд өөрийн албан ёсны элчийг Томск хот руу илгээсэн нь сурвалжаас тодорхой байна.

Сурвалжаас үзэхэд Сэнгэ, Цөхүр увш нарын илгээсэн 2 дахь элчийн хамт Томск хотоос В.Литасов хэмээх анхны хариу элчийг илгээжээ. Тухайн үед Сэнгэ хунтайж орос элч В.Литасовтай уулзах үедээ “Урьд жилүүдэд ...халимагийн тайш миний овоо Хархул ба миний эцэг Баатар хунтайжид эзэн хаанаас, Москвагаас хааны хишиг ихийг илгээж байсан. Миний эцэг Баатар хунтайжаас хойш Сэнгэ надад эзэн хаанаас ч, улсын хотуудаас ч элч ирж байсангүй...”¹⁰ хэмээн хэлж байсан нь Оросын эзэн хааныг өөртэй нь Баатар хунтайжийн адил хандаж, харилцахыг хүсэж, Орос улсаас элч ирэхийг битүүхэндээ хүлээж байсан бололтой. Дээрх элчид Сэнгэ хунтайж “Орос улстай сайн харилцаатай байх, Томск хотод худалдаа хийх” хүсэлтэй байгаагаа мэдэгдэж байв.

Оросын элч В.Литасовын дараа В.Бубенный, П.Кульвинский, В.Былин, М.Ржицкий

3. Материалы по истории русско-монгольских отношений. 1654-1685. Сборник документов. Сост. Г.И.Слесарчук. Отв.ред. Н.Ф.Демидова. М.,1996. с.220, 226

4. Мөнгэнд. с.108

5. Мөнгэнд. с.17-18, 21-24, 44-45, 49-54, 66-71, 75-78

6. Златкин И.Я. История Джунгарского ханства. М.,1983. с.140

7. Чимятдоржиев Ш.Б. Взаимоотношения Монголии и России XVII-XVIII вв. М.,1978. с.54

8. Златкин И.Я. История Джунгарского ханства. М.,1983. с.140

9. Далай Ч. Ойрад Монголын түүх. Тэргүүн боть. УБ.,2002. т.131

10. Материалы по истории русско-монгольских отношений. 1654-1685. Сборник документов. Сост. И.Слесарчук. Отв.ред. Н.Ф.Демидова. М.,1996. стр.108

гэсэн элч нар ээлж дараалан Сэнгэ хунтайжийн өргөөнд ирсэн юм. Тэдгээр элч нар Сэнгэ хунтайжийг ятган Оросын харъяат болгох зорилготой байв. Харин Сэнгэ хунтайж Сибирийн хотуудад нүүн очсон тэлэнгид нарыг өөрийн харъяат албат гэж үзэж, тэднийг эргүүлэн өгөхийг хатуу шаардаж байсан юм.

1665 онд Ойрадад ирсэн Оросын элч В.Бубенныйд Сэнгэ хунтайж *"Урьд манай аав Хунтайж ... Тарын барабинчуудыг довтлон... 700 барабинчуудыг олзлон авч байв... Эзэн хааны зарлигаар миний эцэг Хунтайж тэдгээр хүмүүсийг ... 700 хүнийг ... Тар хот руу илгээсэн... Эцэг хунтайжийн дараа түүний улсуудыг Сэнгэ би эзэмшин захирч байна. Сэнгийн албатууд хоол ундны дутмагаас болж Томск хот руу явсан ба тэдгээр ... тэлэнгид нар одоо Томскт амьдарч байна. Эзэн хааны захирагч нар тэднийг өгөхгүй байна. Миний элч нарыг Москва руу, эзэн хаан руу явуулахгүй байна... Урьд нь би элч В.Литасовыг буцахад тэлэнгидийн тухай асуудлаар элч илгээж байсан..."*¹¹ гэж гомдол мэдүүлж, тэлэнгид нарыг эргүүлэн өгөхийг дахин шаарджээ.

Баатар хунтайж тэрхүү татаруудыг Орос улсад буцаан өгсөнөөр Ойрад-Оросын харилцаа найрамдалтай болж байсныг дурдсан нь Оросын төр засаг үүний адил тэлэнгид нарыг өөрт нь буцаан өгч, хариу барих ёстойг сануулахын зэрэгцээ ингэж чадвал Баатар хунтайжийн үеийн адил хоёр улс найрсаг харилцаатай байх болно гэсэн хариу мэдэгдэж байв. Мөн *"Эцэг хунтайжийн дараа түүний улсуудыг Сэнгэ би эзэмшин захирч байна"* хэмээн хэлсэн нь зөвхөн Ойрадын газар нутгийг төдийгүй түүний харъяат байсан албат ардыг захирах болсон гэсэн санааг давхар илтгэсэн хэрэг юм.

Тухайн үед Сибирийн ард түмэн хэн хүчтэй байна түүнд сайн дураар даган орж, алба барьж, өөрийн гадаад аюулгүй хангахыг хичээж байсан үе юм. Гэвч Орос, Ойрад, Хотгойдын аль нь ч тэдний аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаггүй байсан төдийгүй бүгд тэднээс алба авахыг хичээж, эцэстээ Ойрад, Хотгойд хоёр Сибирийн ард түмнээс Орос улсын алба авах явдлыг аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрдөг байв. Ингэснээр тэдгээр жижиг овог аймгууд "хоёр улсын албат, хоёр улсын харъяат", зарим тохиолдолд "гурван улсын", "дөрвөн ч улсын албат, харъяат" болж байсан онцлогтой. Ингэхдээ хоёр улсын харъяат болвол Ойрад-Оросын, Хотгойд-Оросынх гэж болж байснаас бус Ойрад-Хотгойдын албат, харъяат болж байсан тохиолдол үгүй. Энэ нь Ойрад-Хотгойд хоёр хоорондоо байнгын дайн самуунтай байсанд оршино. Ийм замаар өмнөд Сибирьт үүсээд байсан хурцатмал байдал хэсэг хугацаанд намжиж байв.

Сэнгэ хунтайж тэлэнгид нарыг дипломат аргаар буцаан авах оролдлого нь амжилтанд хүрэхгүй байсан учир элчийг саатуулах, Оросын эзэн хаанд сүрдүүлсэн захиа илгээх, элч нарыг үл хүндэтгэх, хааны хишигт үл хүндэтгэл үзүүлэх зэргээр дарамт үзүүлж байсан. Тухайлбал элч В.Бубенныйг гэдрэг буцаалгүй жил орчим өөрийн нутагт саатуулжээ. Эцэст нь түүнийг явуулсан ба үүний шалтгааныг орос сурвалжид *"намайг (Сэнгэ хунтайж) Хотгойдын Лувсан хантай байлдахад Оросын эзэн хаанаас түүнд 2000 албаны хүмүүсээр тусална гэсэн мэдээ Монголоос ирлээ"* гэж хэлээд өөрийн элч Урянк, Галдангийн элч Тархан нарыг дагалдуулан түүнийг нутагт нь буцаасан байна.¹² Ямартаа ч Сэнгэ-Лувсан нарын тэмцэлд Орос улсаас Лувсан тайжид цэрэг илгээж тусалсан талаар баримт мэдээ байхгүй байгаа ба энэ нь өөрийн элчийг буцааж авах, Сэнгийг айлгах гэсэн Оросын зүгээс тараасан цуурхал ч байж магадгүй юм.

Сэнгэ хунтайж Оросын хаан Алексей Михайловичид *"...миний эцгийн үед ...Томск руу элч илгээхэд Томск хотын захирагч саатуулахгүйгээр эзэн хаан руу илгээж байсан. Харин Сэнгэ би урьд өөрийн элч нарыг эзэн хаан тань руу илгээсэн боловч Томск хотын захирагчаас миний элч нарыг тань руу явуулж байсангүй... Би Аблай тайш, Абла хан, Урдун хантай зөрчил*

11. Мөн тэнд, с.140-141

12. Материалы по истории русско-монгольских отношений. 1654-1685. Сборник документов. Сост. И.Слесарчук. Отв.ред. Н.Ф.Демидова. М.,1996, с.141

тэмцэлтэй байсан ч би тэд нартай найрамдсан. Иймд би тань руу өөрийн элчийг илгээж, ... мэдэгдэж байна. Томскт нутаглаж буй цагаан халимагуудыг (тэлэнгидийг-Н.Б.) Сэнгэ тайш надад өг... Таны зарлигаар буюу захирагч нар өөрсдийн хүслээр Томск хотоос казахуудыг илгээн цагаан халимагуудтай дайтаж байна... Бидний элчийг саатуулахгүй илгээнэ үү"¹³ гэсэн захидал илгээжээ. Энэ нь урьдын адил ойрадууд эвтэй, хүчтэй болсоныг Орос улсад мэдэгдэхийн зэрэгцээ тэлэнгид нарыг цэрэглэн довтолж байгаад дургуйцлээ илэрхийлсэн байна. Ийнхүү Оросын хаанд хандсан захиа илгээсэн учир В.Бубенный элчтэй хамт явсан Сэнгэ хунтайжийн элч Урянкийг Москвад анх удаа хүлээн авсан юм.

Удалгүй Ойрал-Оросын харилцаанд таагүй уур амьсгал бий болж эхэлсэн ба Сэнгэ, Цөхүр увш нар Оросын ээлжит элч П.Кульвинский, В.Былин, М.Ржицкий нарт хүндэтгэл үл үзүүлж, тэдэнтэй ширүүн харьцаж байв. Тэдгээр элч нар Сэнгэ, Цөхүр увш нарын тэлэнгидийг эргүүлэн авах хүслийг орхигдуулах зорилготой очиж байв. Тэдгээр элч бүр Сэнгэ болон Цөхүр увш нарыг "хааны амар мэндийг асуусангүй, хааны илгээсэн хишгийг босч авсангүй, өөрөө авсангүй" хэмээн гомдол мэдүүлж, Оросын их хааныг хүндэтгэхгүй байна гэж үзэж байв. Оросын элч нарт ийнхүү хандах, Москва болон Сибирийн захирагч нартай харьцаа муудах болсон нь Сэнгэ хунтайж, Цөхүр увш нар Дээд Енисейн кыргызчуудад ноёрхлоо тогтоосон Хотгойдын Алтан хан Лувсан тайжийг бут цохисонтой шууд холбоотой болно. Сурвалжийн мэдээгээр Сэнгэ хунтайж Лувсан тайжийг эгч, эхнэр, 3 хүүгийн хамт олзлон авчээ. Тэр үеэс хойш тэлэнгид нарыг түүнд буцаан өгөхгүй бол түүний эзэмшил Сибирийн хотуудыг уулгалан довтолох тухайгаа Оросын хаанд мэдэгдэж, сүрдүүлэх болсон байдаг. Энэ нь Сэнгэ хунтайж, Цөхүр увш нарын Оросын элч нарт хэлсэн үгнээс тодорхой харагдана.

1667 онд Ойрадын нутагт ирсэн Оросын элч П.Кульвинский эзэн хааны захиа ба хишгийг босч авах ёстой гэсэн шаардлага тавихад Цөхүр увш ихэд уурлан: "Урьдах тайшуудын үед ч, Чохур миний үед ч хаан эзний бэлэг ба захиаг авахдаа суухгүй босч зогсоод авсан жишээ ерөөсөө байхгүй. Түүний захиа ба бэлгийг хүлээн авахдаа өөрийнхөө нэр хүндээ алдаж түүнд ёслох би түүний харъяат уу? ... чи нөхдийнхөө хамт эзэн хааныхаа захиа ба бэлгийг авсанд миний нутгаас гарч Томск руугаа яв"¹⁴, "Хэрвээ эзэн хаан бидний харъяат тэлэнгидийг өгөхгүй, энэ асуудлыг түргэн шийдэхгүй хойшлуулсаар байхын бол Цохур убаш би эзэн хааны харъяат хот Томскийг довтолох болно" гээд дуугаа өндөрсгөн, гараа сунган "Намайг саадаг татаж, сэлмээр цавчиж, буудаж чадахгүй болсон гэж үзэж байна уу? ... чи надаас сонссоныгоо эзэн хаандаа хэлээрэй. Хоёр улсын хооронд хэрүүл маргаан ба дайн байсангүй. Дайн байдлаан сайн уу? Эсвэл энх тайван сайн уу?"¹⁵ гэж сүрдүүлэн хэлж байв.

Тухайн үед Сэнгэ хунтайж тэлэнгид нарыг буцааж өгөхийг Оросын хаанаас шаардсан хэвээр байв. Оросын элч В.Былинд хандан Сэнгэ хунтайж "хэрвээ эзэн хаан надад тэлэнгидийг өгвөл би эзэн хаанд ямар ч муу юм хийхгүй, эзэн хаантай өөрийн эцгийн адил найрамдалтай амьдарна. Би тэлэнгидийн тухай асуудлаар эзэн хаанд 6 удаа элч илгээсэн, эзэн хаан надад тэднийг өгөхгүй байна. ... Томск, Кузнецкийн шивээг довтолно"¹⁶ гэж сүрдүүлж байсан юм.

Үүнийг Оросын судлаач И.Я.Златкин "...Сэнгийг хүртэл тийм өнгөөр нэг ч удирдагч, нэг ч Монголын ноён ярьж байсангүй. Үүнийг хэрхэн тайлбарлах вэ" гээд "үүнийг зөвхөн Лувсан тайжийг бут цохисонтой холбох бус Сэнгийн хант улсын бэхжилттэй холбох нь эргэлзээгүй юм"¹⁷ гэж дүгнэжээ. Үнэхээр ч Сэнгэ дотоод байдлаа бэхжүүлж, нэгэн удирдлага дор оруулж

13. Мөн тэнд. с.134-135

14. Мөн тэнд. с.149

15. Материалы по истории русско-монгольских отношений. 1654-1685. Сборник документов. Сост. И.Слесарчук. Отв.ред. Н.Ф.Демидова. М.,1996. с.154

16. Мөн тэнд. с.188

17. Златкин ИЯ. История Джунгарского ханства. М.,1983. с.145

чадсан учраас гадагш дайн хийж, ялсан явдал юм. Ийнхүү ойрадууд дахин хүчирхэгжиж ирэхэд Сэнгэ хунтайж ба Кыргызийн Ереняк ноён нарын хооронд Оросын улсын эсрэг цэрэг-улс төрийн холбоо тогтоосон юм. Үүнийг судлаач О.В.Боронин “Сэнгэ-Ереняк нарын хооронд бий болсон эзэн-албатын харилцаа нь удалгүй цэрэг-улс төрийн холбоо болсон ба үүнд ойрадууд ахлах, харин кыргызууд дагах байр суурьтай байжээ”¹⁸ гэж Сэнгэ-Ереняк нарын хоорондын харилцааны мөн чанарыг оновчтой тодорхойлжээ.

1668-1670 оныг хүртэл хугацаанд Ойрад-Оросын хооронд элч солилцсонгүй, хоёр талын харилцаа 2 жил түр завсарласан байна. 1670 онд Ойрадад ирсэн элч М.Ржицкийд Сэнгэ хунтайж “эцэг Хунтайж татар хүмүүсийг буцаан өгснөөр хоёр улсын хооронд хэрүүл маргаан гарч байгаагүй, өөрийн албат тэлэнгидийг буцаан өгөхгүй бол Томск хотыг довтлох” тухайгаа дахин сануулж, “...Харин би эзэн хаанд өөрийн хүмүүс цагаан халимагуудыг олон жил гуйж байгаа боловч эзэн хаан надад өгөхгүй байна. Үүнээс хойш надад миний хүмүүс цагаан халимагуудыг өгөхгүй тодийгүй Томскоос надад элч илгээхгүй байгаа тул Томск хотыг довтлох болно”¹⁹ гэсэн мэдээ нь хоёр талын харилцаа хэсэг хугацаанд тасарсаныг харуулж байна.

1670 оноос Сэнгэ, Цөхүр увш нар Тобольск хот руу элч илгээж, түүгээр дамжуулан Оросын төр засагтай харилцах болжээ. Энэ удаад Оросын хаан Цөхүр увш, түүний хүү Баахан Манж нарын элч нарыг хүлээн авахаа мэдэгдэж, харин Сэнгийн элчийг Тобольскоос Ойрад нутаг руу нь буцаажээ.²⁰ Оросын энэ үйлдэл нь Сэнгэ хунтайж, Цөхүр нарыг өөр хооронд нь эвдрэлцүүлэх, Сэнгийн хүч нөлөөг бууруулах, ингэснээрээ тэлэнгидийг тэдэнд өгөхгүй байх гэсэн оролдлого байв. Орос сурвалжид Сэнгийг “тайш” гэж бусад Ойрадын ноёдтой адилтган бичиж үлдээсэн байдаг. Сэнгэ хунтайж Тобольск хотын элчийг хүндэтгэн хүлээн авч, түүнд “тэлэнгид нарыг өгөхгүй бол Хятад руу явсан Оросын худалдаачдыг буцах замд нь саатуулах болно...”²¹ гэж хатуу мэдэгдсэн байна. Сэнгэ хунтайж өмнө нь тэлэнгидийг эргүүлэн өгвөл Хятадыг зорьж буй Оросын элч, худалдаачдыг уналга, хоол хүнс, газарчинаар хангаж туслахаа удаа дараа мэдэгдэж байсан билээ.

Дээд Енисейн кыргыз, тува нар Оросын хаанд алба төлөхөөс гатгалзаж, Сэнгэ хунтайжид алба төлж байгааг Сибирийн хотуудын захирагч нар эзэн хаандаа гомдоллон мэдээлж байв.²² Энэ байдал нь Сэнгэ хунтайжийг Орос улсаас өөрийн албат ардаа эргүүлэн авах бодлоготоо тууштай зогсоход нөлөө үзүүлж байв. Кыргыз, тува нар Баатар хунтайжид алба төлж, хариуд нь өөрсдийн гадаад аюулгүй байдлыг хангаж байсан Ойрадын хараат албат байв. Баатар хунтайжийн дараа Ойрадад өрнөсөн хямрал, Хотгойдын Лувсан тайжийн довтолгоон зэргээс шалтгаалан өөрсдийн гадаад аюулгүй байдлыг хангах үүднээс Оросын эзэн хааны ивээлд орсон боловч Орос улс тэднийг Хотгойдын Лувсан тайжаас хамгаалж чадаагүй юм. Иймд тэд Орос улсад алба төлөхөөс татгалзаж, Сэнгэ хунтайжийг түшиж, түүнд өөрсдийн дураар алба өгч байсныг “...Мөн тувачууд халимагийн хүмүүст итгэн ... их хаанд алба төлөхгүй байна...”²³ гэсэн баримтаас харж болно.

Кыргыз, тува нар өөрсдийн дураар, өөрсдийн гадаад аюулгүй байдлыг хангахын үүднээс Сэнгэ хунтайжид алба төлж байсныг Оросын судлаач Б.П.Гуревич “гэр (Сэнгэ) Орос улсад алба төлж байсан кыргызуудээс өөртөө мөн тийм алба төлөхийг албадаж байсныг орос

18. Боронин О.В. Двоеданничества в Сибири XVII-60-е гг. XIX в. Барнаул..2010. с.85

19. Материалы по истории русско-монгольских отношений. 1654-1685. Сборник документов. Сост. И.Слесарчук. Отв.ред. Н.Ф.Демидова. М.,1996.с.210-211

20. Мөн тэнд. с.220-221

21. Мөн тэнд. с.220

22. Материалы по истории русско-монгольских отношений. 1654-1685. Сборник документов. Сост. И.Слесарчук. Отв.ред. Н.Ф.Демидова. М.,1996. с.217-218

23. Мөн тэнд. с.218

сурвалжууд харуулж байна”²⁴ гэж ташаа дүгнэсэн байна.

Сэнгэ хунтайж Орос улстай албат ардаас болж ийнхүү дайсагнасан харилцаатай байсныг Ч.Далай “Хэдийгээр Сэнгэ Красноярскийн хавь, Халимаг, Киргизийн орчмоор газар нутаг, хүн ард булаацалдан, Оростой орон нутгийн чанартай дайн тулаан хийдэг байсан нь шударга бус үйлдэл мэт боловч нутаг дэвсгэрээ умард зүгт тэлэн өргөтгөж, Зүүнгарын хаант улс байгуулах гэсэн санаархлын эхлэл байсан гэлтэй”²⁵ гэж дүгнэсэн байна.

Орос сурвалж болон судалгааны зохиолуудад Сэнгийн үеийн Ойрад-Оросын харилцаа нэлээд ээдрээтэй, төвөгтэй байдалд хүрсэн явдал нь Оросын албат байсан тэлэнгид нарыг Сэнгэ хунтайж хүчээр авах гэсэн үйл ажиллагаатай холбоотой мэт ойлголт өгөхөөр бичиж, дүгнэсэн байдаг. Гэвч энэ асуудлыг хоёр талтай авч үзэх нь зүйтэй болов уу. Нэг талаас Сэнгэ хунтайж өөрийгөө Баатар хунтайжийг залгамжилсан учир түүний эзэмшил төдийгүй Ойрадын харьяат албат ардыг захирч, тэднээс алба авах ёстой хэмээн үзэж, Оросын улсыг өөртэй нь Баатар хунтайжийн адил хүндэтгэлтэй хандаж, харилцахыг шаардаж байсан. Гэтэл тухайн үеийн Ойрадын дотоод байдал тогтворгүй, ноёдын өөр хоорондын тэмцэл нь Сэнгийн байр суурийг ганхуулах, Орос улс түүнийг Баатар хунтайжийн адил үнэлэхгүй байхад нөлөө үзүүлжээ. Нөгөө талаас Москва Сэнгэ хунтайжийн элчийг хүлээн авахгүй байх, тэднийг саагуулах, тэлэнгид нарын асуудлаар ямар нэгэн хариулт өгөөгүй зэрэг нь хоёр улсын харилцаа муудахад нөлөө үзүүлжээ. Тэлэнгид нарыг буцаан авахын тулд Сэнгэ хунтайж Орос улсад буулт хийж, Оросын элч худалдаачдыг Хятад руу аюулгүй явах нөхцлөөр хангах зэрэг амлалт өгч байсан ч үр дүнд хүрээгүй юм. Мөн Сэнгийн Орос болон Сибирийн овог аймгуудын талаар баримталж буй байр суурийг нь ашиглан, Оросын эсрэг тэмцэлд болон өөрийн аюулгүй байдлыг хангах төдийгүй тува зэрэг урьдын албат ардаас урьдын адил татвар авах гэсэн Кыргызийн ноёдын санаархал Сэнгэ-Оросын зөрчлийг улам дэвэргэж байсан гэлтэй.

Огүүлэн буй үед монголчуудад Оросоос гадна Манж Чин улс аюул занал учруулж байсан юм. Иймд Сэнгэ хунтайж дотоод, гадаад нөхцөл байдлаа мэдрэн, Орос улстай уян хатан байдлаар харилцах улс төрийн бодлого баримтлах ёстой байв. Түүний эцэг Баатар хунтайж хоёр улсын харилцааг муутгахгүйн тулд Ойрадын нутагт зугтан ирсэн татаруудыг оросуудад буцаан өгч, киргиз, тува, татар зэрэг ард түмнийг Ойрад-Оросын харьяат (двоеподданство), хоёр улсад алба төлөгч (двоеданничество) хэмээн үзэж, Орос улстай үүссэн зөрчлийг ийнхүү шийдэж байсан юм. Харин Сэнгийн хувьд тэлэнгид, кыргыз, тува нарыг өөрийн албат хэмээн үзэж, лингаар ноёрхохыг илүүд үзсэн төдийгүй Оросын ноёрхолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан юм.

Сэнгэ хунтайж Оросын хаанд түүний албат Сибирийн захирагч нарын адил зүтгэх биш, харин Ойрад, Орос гэсэн хөрш улсын ёсоор харилцахыг эрхэмлэж байв. Тиймээс Орос улсаар Сибирьдэх Ойрадын ноёрхлыг дипломат арга, хүч хэрэглэн зөвшөөрүүлэхийг оролдож байсан гэж үзэж байна.

Сэнгэ хунтайж Орос улстай зөрчилдөх болсонд ойрадууд Хотгойдын Алтан хан Лувсан тайжийг бүрмөсөн дарсан явдал нөлөө үзүүлжээ. Өөрөөр хэлбэл Ойрадын ноёд Хотгойдын аюул хүчтэй байх үед Орос улсыг түшиж, түүнтэй харилцаагаа муутгахгүй байхыг гол болгож байсан бол Сэнгийн үед Орос улсыг түших гадаад шалтаан үгүй болсон юм. Гэвч Оросын төр засаг ойрадуудыг өөрийн хараат улс, албат хүмүүс мэтээр хандаж, харьцсан хэвээр байв.

Эцэст нь хэлэхэд Сэнгийн үед үүссэн Ойрад-Оросын таагүй харилцаа удаан үргэлжилсэнгүй, Галдан бошгот хааны үед хоёр улсын найрсаг харилцаа дахин сэргэсэн билээ.

24. Гуревич Б.П. Международные отношения в Центральной Азии в XVII-первой половине XIX в. М., 1983. с.35

25. Далай Ч. Ойрад Монголын түүх. Тэргүүн боть. УБ., 2002. т.131

MAIN ISSUES OF SENGE AND RUSSIAN RELATIONSHIP

After the death of Batur-khuntayshi, his eldest son Senge inherited his supreme authority among the Oirat. During the reign of Senge khuntayshi main issue of the Oirat-Russian diplomacy was tributary and subject status of the Siberian small nations, mainly of Telungut and Kyrgyz, which was claimed by both sides. Despite some compromise by Senge, the position of Oirats on them, was pretty strict and had corresponding reactions from Moscow.

We can characterize Oirat-Russian relationship into two stage:

1. 1663-1666: fairly normal relations between the two countries, despite the chronic problem of subjection of Telenguts, which were constantly claimed by Senge.

2. 1666-1670: the tense situation between the Oirat and Russian due to Telenguts and other small peoples of Siberia. Senge has deliberately humiliate Russian envoys, threaten Siberian governor, and attack merchants who were resulted the denial of his leading position in the Oiratia with by Moscow.

Soon after the death of Senge, his younger brother Galdan Boshgotu quickly restored normal relation between two countries.